

10

ШИЛЖИЛТИЙН ҮЕИЙН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ

Д.Бадарч, Х.Эрдэнэчулуун

Төвлөрсөн эдийн засаг үр ашиггүй болох нь нэгэнт тодорхой болсон ХХ зууны 90-ээд оны эхээр төрийн өмчийн монополийг халах, удирдлагын төвлөрлийг задлах, хувийн өмчийн институт дээр суурилсан зах зээлийн харилцааг сэргээх нь зайлшгүй болохыг бүгд ойлгосон гэдэгт хэн ч маргахгүй нь тодорхой.

Үр ашиг муутай эдийн засаг хүн амын байнга өсөн нэмэгддэг зүй тогтол бүхий хэрэгцээг хангах чадваргүй учраас, цаашид энэ байдал удаан үргэлжилбэл, хүн амын амьжиргааны түвшин хэзээ ч дээшээ гарахгүйгээр унах, энэхүү уналтыг жаахан ч гэсэн сааруулахын тулд байгалийн баялгаа улам бүр үрэн таран хийх, түүнээс улбаатай дотоод, гадаад зөрчил, тэмцэл, сөргөлдөөн үүсэх магадлал ХХ зууны сүүлээр бий болсон юм.

Үүний зэрэгцээ, өндөр хөгжилтэй орнууд эдийн засгийн өсөлтөө хангахын тулд ХХ зууны сүүл болоход улам бүр их байгалийн нөөц баялгийг эргэлтэд оруулахыг зорих болсон нь хүрээлэн буй орчныг бохирдуулах, баян, ядуу орнуудын хөгжлийн түвшинг улам бүр холдуулах зэрэг глобаль шинж бүхий хурц асуудлыг бий болгосон юм.

Дээр дурдсан болон, бусад асуудлууд нь нэгдүгээрт, нийгэм-эдийн засгийн тогтолцооны шилжилт хоёрдугаарт, тогтвортой хөгжил хэмээх орчин үеийн хоёр глобаль шинж бүхий асуудлыг судлан шинжилж, шийдвэрлэх шаардлагыг бий болгосон юм.

Өнөөдөр нийгэм-эдийн засгийн тогтолцооны шилжилтийн хандлагыг дараахь байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Эдийн засгийн бодлого боловсруулан, хэрэгжүүлэх замаар, макро эдийн засгийн үйл явцыг зохицуулах,
- Эдийн засгийн өсөлтийн шинэ эх үүсвэрийг бий болгох, эдийн засгийн бүтцийг бүрдүүлэх боломж олгохуйц макро эдийн хөгжлийн техник-технологийг бий болгох,
- Эдийн засгийн нөөцийн хуваарилалтын хамгийн үр ашиг бүхий арга нь зах зээлийн эдийн засаг, аж ахуй эрхлэлтийн идэвхтэй үйл ажиллагаа болохыг хүлээн зөвшөөрөх, нотлох,

- Макро эдийн засгийн үр ашгийн өсөлтийг шалгуур болгон, эдийн засгийг нээлттэй болгох хэмжээ, хэлбэрийг тогтоох.

- Нийгмийн чиг баримжаа бүхий тогтвортой нийгмийг бий болгох.

Эдгээрээс, нийгмийн чиг баримжаа бүхий тогтвортой нийгмийг бий болгох нь шилжилтийн эрин үеийн хөгжлийн хамгийн гол хандлага болж байна. Үүнийг нийгмийн (social) болон чөлөөт (liberal) арга замаар жолоодон чиглүүлдэг ажээ.

Нийгмийн /social/арга зам нь үнэ төлбөргүй суурь боловсрол олгох, нийгмийн хамгаалал, нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлого хэрэгжүүлэх замаар хүнийг хөгжүүлэх, зах зээлийн эрсдлээс сэргийлэх хэлбэрээр хэрэгждэг байна. Энэ нь орчин үед эдийн засгийн нөөц, хүчин зүйлээс илүүтэйгээр, иргэдийн аж байдлын асуудал эдийн засгийн өсөлт, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх хамгийн чухал хүчин зүйлс болж байна.

Либерал арга замын онцлог нь зах зээлийн эдийн засгийн харилуааны сул талыг зөөлрүүлэхэд төрийн оролцоо чиглэн, өрсөлдөөн эдийн засгийн өсөлтийн үндсэн хэрэгсэл болдог явдал юм.

Энэ үед, үйлдвэрлэгч бүрийн тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд оруулж буй оролцоог үнэлэх замаар, түүний хэрэгцээг хангах үүргийг зах зээл хүлээнэ. Энэ арга замыг хэрэгжүүлснээр, нийгмийн давхарга бүрт хүртэх орлогоос хамаарал бүхий, ялгавартай нийгмийн хамгааллын тогтолцоо, нийгмийн давхаргын орлогын ялгаварлал, хойч үеийн үйл ажиллагааны гарааны тэгш бус нөхцөл ажиглагдагддаг. Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, нийгмийн давхарга бүрт ялгавартай тусламж үзүүлэх нь тухайн арга замын үндсэн зорилт юм. Энэ арга зам нь нийгмийн тогтворгүй байдал, зөрчил үүсгэж болох сөрөг талыг агуулдаг байна.

Орчин үед, Шведэд хамгийн тодоор илэрдэг хойт-европын загвар, ХБНГУ-д нийгмийн чиг баримжаа бүхий зах зээлийн аж ахуйн загвар, эдийн засгийн хөгжлийн ба нийгмийн тогтвортой байдлыг хангах японы загвар зэрэг нийгмийн тогтвортой байдлыг хангах үндэсний өвөрмөгц загварууд бий болсон бөгөөд эдгээр нь дээрхи арга замыг үгүйсгэж байна. Улс орон болгоны сонгосон загварууд өөрийн онцлогийг агуулж буй бөгөөд дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ (ДНБ) 39,9%-ийг нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулан, мөнгөн орлогын дахин хуваарилалтыг төрөөс зохицуулж байгаа буй нь шведийн загварын, ДНБ-ийхээ 27,5%-ийг энэ зорилгод зориулан, үр бүтээлтэй хөдөлмөрлөхийн төлөө хүн бүр хувийн хариуцлага хүлээдэг, эдийн засгийн субъектуудын эв санааны нэгдэл дээр суурилдаг нь германы загварын, ДНБ-ийхээ 16%-ийг үүнд зарцуулан, том корпорациуд ажилтнуудынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд онцгой үүрэгтэй болохыг товойлгодог нь японы загварын онцлог юм. Нийгмийн тогтвортой байдлыг хэрхэн хангаж буйг эдгээр үндэсний загварууд харуулж байна.

Бүтцийн ба институциональ өөрчлөлтийг хийх замаар нийгмийн тогтвортой хөгжлийн хэв маягийг бий болгосноор макро эдийн засгийн хөгжлийн нийтлэг хандлага бүрэлдэнэ.

Бүтцийн өөрчлөлт нь эдийн засгийн сектор, салбаруудын үйл ажиллагааны зарчмыг өөрчлөхөд чиглэдэг бол, институциональ өөрчлөлт нь бүтцийн өөрчлөлтийн зохион байгуулалтын функциональ хэлбэр юм.

Макро эдийн засгийн бүтцийн ба институциональ өөрчлөлт нь нэг удаагийн бус, урт хугацаанд үргэлжилдэг үйл явц гэдэг нь ойлгомжтой.

Таван зуугаад жилийн турш эдийн засгийн субъектуудын үйл хөдлөлийн норм, институтын хөгжлийн явцад, өнөөдрийн нэгэнт төлөвшсөн зах зээлийн эдийн засгийн институциональ орчин бүрэлдсэн билээ.

Шилжилт хийж буй эдийн засагт институциональ өөрчлөлт хийнэ гэдэг нь макро эдийн засгийн бүхий л түвшинд шинэ институтууд бий болгоно гэсэн үг юм. Тухайн улсын макро эдийн засгийн зах зээлийн шинж чанарыг макро түвшинд шинээр буй болгосон институтууд тодорхойлох болно. Үүний дотроос эдийн засгийн субъектуудад бие даасан шийдвэр гаргах харьцангуй эрх чөлөө олгодог, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлдог, нөөцийг үр ашигтай эргэлтэд оруулах боломж олгодог тул хувийн өмчийн институт хамгийн чухал юм.

Нэгэнт тогтсон макро эдийн засагт дэд бүтцийн элементуудын үр ашиггүй нь алга болж, үр ашиг бүхий шинэ элементууд шинээр бий болж байдаг бол, шинээр буй болж макро эдийн засагт дэд бүтцийн зарим элемент огт байдаггүй ба институциональ орчны зарим нь бүрэлдээгүй, зарим нь шинэ нөхцөлд таарахаа больсон байдаг тул тэдгээрийн оронд цоо шинээр бий болгох бодит шаардлага гардаг. Учир нь ийм байдал мэдээллийн тодорхой бус байдлыг бий болгон, эрсдлийн түвшинг нэмэгдүүлэн, бараа, үйлчилгээний зардал, үнийг өсөлтийг бий болгоно.

Макро эдийн засгийн хөгжлийн нэг түвшингээс түүнээс илүү өндөр түвшинд хүрэхийн тулд дараахь асуудлуудыг шийдвэрлэх хэрэгтэй байдаг байна. Үүнд:

- Шинэ түвшинд ямар институт (байгууламж) шаардлагатай болохыг шийдэх.
- Нэгэнт байгаа институтийн алийг нь шинэчилж, алинаас нь татгалзахыг шийдэх.
- Татан буулгаж буй болон шинээр бий болгож буй институтууд ямар холбоотой болохыг тодруулах,
- Эдгээр институтийн аль нь нийтлэг, аль нь нийтлэг бус болохыг тодруулах.
- Тэдгээрийн хооронд ямар зөрчил үүсч болох, тэдгээрийг хэрхэн шийдэх арга замыг тодорхойлох.

Макро эдийн засаг нь институт байгууламж болохын хувьд нийгмийн шинж чанартай байдаг нь эдийн засгийн эрх мэдлийн төвлөрлийг бууруулахыг шаарддаг. Зайлшгүй шаардлагатай институциональ орчин бүрдээгүй үед эдийн засгийн бүтэц өөрийн хөдөлгөгч хүчийг хөдөлгөөнд оруулж чаддаггүй нь хуучинсаг үзэл, эдийн засгийн субъектуудын хөшүүн байдал, гэмт хэрэг-мафиин шинжтэй эдийн засагтай холбоотой байдаг.

Институциональ ба бүтцийн өөрчлөлт нь цар хүрээ, иж бүрдлийн хувьд ялгаатай байдаг болохоос бус, бүхий л макроэдийн засагт хамааралтай асуудал юм.

Макроэдийн засаг нь мөчлөгийн шинжтэй ба шилжилт хийж буй эдийн засгийн мөчлөгийн талаарх судалгаа бараг хийгдээгүй дөнгөж эхлэлтийн төдий байна. Ялангуяа, эдийн засгийн мөчлөгийн уналтын асуудал практик дээр тулгамдсан шинжтэй бөгөөд, түүнийг судлан, даван туулах арга зам боловсруулах нь өнөөгийн чухал асуудал болж байна. Уналт нь борлуулагчийн зах зээлээс худалдан авагчийн зах зээл рүү шилжих, эдийн засгийн бүтэц, зохицуулалтын механизмд өөрчлөлт орох, санхүүгийн механизмын хоцрогдол, макроэдийн засгийн байнга муудаж буй эрэлт зэргээс шалтгаалдаг боловч,

шинээр буй болсон нийгэм-эдийн засгийн нөхцөлд макроэдийн засгийн бүтэц тохирохоо больсны улмаас макроэдийн засаг цочролд орсон нь шилжилтийн үеийн уналтын үндсэн шалтгаан юм. Үүний нэг илрэл нь шилжилтийн үед стагфляци удаан үргэлжлэх, мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлээд байхад үнийн түвшин буурдаг явдал юм.

Үр ашиггүй салбарыг хаан, өндөр үр ашиг бүхий салбарт үйлдвэрлэл явуулахад шаардлагатай нөөцийн дахин хуваарилалтын механизм бий болоогүй байдаг нь мөчлөгийн бус, шилжилтийн үеийн уналтын хямрал буйг харуулна. Хүмүүсийн амьжиргааны түвшин доошлох, орлогын ялгаварлал, ядуурал хүчтэй явагдах нь энэ хямралын гол шинж юм. Нэг талаас, бүтцийн ба институциональ өөрчлөлт удаан явагдах, нөгөө талаас, нийгмийн зарим хэсэг энэ өөрчлөлтийг зөвшөөрч, хүлээн авдаггүй байдал шилжилтийн үеийн хямралыг мухардалд оруулах талтай юм. Ингэснээр, макро эдийн засгийн тодорхой бус байдал нэмэгдэн, эдийн засаг дахь төрийн макро эдийн засгийн бодлогын ач холбогдол улам бүр өсөн нэмэгдэнэ.

XX зууны сүүл, XXI зууны зааг дээр бүтцийн ба институциональ өөрчлөлтүүд төрийн санаачлагаар, түүний дэмжлэгээр явагдан, тэрбээр, макроэдийн засагт өөрийн байр суурийг баттай эзэлж байна.

Макроэдийн засгийн шинэ тогтолцоонд шилжилт хийхэд манлайлагч болж оролцох төрийн үүргийг иж бүрэн систем-бүрдүүлэгч гэвэл, эдийн засгийн өдөр тутам зохицуулалтыг тогтворжуулалтын үүрэгтэй гэж ойлгож болох юм. Эдгээр үүргүүд нь зохистой институциональ бүтэц бий болгох үйл ажиллагааг хамарна. Энэ нөхцөлд хөгжлийн чиглэлийн альтернатив чиглэл, гаргаж буй шийдвэрийн үр дагаврын талаар прогноз (таамаглал) дэвшүүлэх асуудал маш чухал юм. Энэ асуудлыг макроэдийн засгийн системчилсэн-бүтцийн прогнозчлолын хүрээнд судалж байна. Макроэдийн засгийн ирээдүйн дүр төрхийг системчилсэн-бүтцийн прогнозчлолын аргаар тооцдог бөгөөд макроэдийн засгийн янз бүрийн түвшин (салбар, бүс нутаг, үндэсний эдийн засаг бүхэлдээ), нийгэм-эдийн засгийн үйл явц (оюуны хүрээнд ба санхүүгийн салбарын хөрөнгө оруулалт зэрэг) нь макро прогнозын объект болдог бол, пропорц, харьцаа зэрэг үзүүлэлтүүд үр дүн болно. Энд нэг талаас, үйлдвэрлэлийн хэмжээ, нөгөө талаас, байнга өсөн нэмэгддэг зүй тогтол бүхий хэрэгцээг хангах нь макро прогнозын тодорхойлогч үзүүлэлт болно. Макроэдийн засгийн зохистой харьцаа түр зуурын тэнцвэрийн үед ч бий болдог тул, үндэсний эдийн засгийн тогтвортой хөгжлийн параметр чухал юм.